

“Алтан тулга, мөнгөн тотго” баримтат кинонд хийсэн шинжилгээ

Басанбаярын Буяннэмэх 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
✉ buyanaa3438@gmail.com

Хураангуй: Энэхүү судалгаанд захчин угсаатны хуримын зан үйлийг харуулсан “Алтан тулга, мөнгөн тотго” баримтат киног сонгож соёлын биет бус өвийг киногоор баримтжуулж хадгалах, олон нийтэд сурталчлах боломж, ач холбогдлыг шинжиллээ. Баримтат кино нь зөвхөн мэдээлэл дамжуулагч бус, соёлын өвийн бүртгэл, хадгалалтын хэрэгсэл болох боломжтой. Судалгааны үр дүнд уг баримтат кино нь захины хуримын зан үйлийг баримтжуулан хадгалах, угсаатны зүйн судалгааны эх сурвалж болохын зэрэгцээ соёлын өвийг орчин үеийн нийгэмд өвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

Түлхүүр үгс: *бэр сонгох, ам сонсгох, зус хадгийн найр, халхаар цайлуулах, хадаг бараалхуулах, хүргэн үзэгдэх*

An analysis of the Documentary “Altan Tulga, Mungun Totgo”

Buyannemekh Basanbayar 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University of
Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ buyanaa3438@gmail.com

Abstract: This study focuses on the documentary film “Altan Tulga, Mungun Totgo”, which depicts the traditional wedding rituals of the Zakhchin ethnic group. It examines the film’s role in documenting, preserving, and disseminating intangible cultural heritage through audiovisual media. As a scholarly inquiry, the research argues that documentary cinema functions not merely as a vehicle for conveying information but also as a vital tool for documenting, safeguarding, and revitalizing cultural practices. The analysis demonstrates that the film effectively captures and preserves distinctive ritual knowledge, provides valuable ethnographic data, and contributes to the intergenerational transmission and contemporary relevance of intangible cultural heritage.

Keywords: *choose bride, am songgokh, zus khadgiin nair, khalkhaar tsailuulakh, presenting the khadag, groom’s formal visit*

Оршил

Уламжлалт хуримын зан үйл нь угсаатны соёлын онцлогийг хадгалж байдаг оюуны соёлын салшгүй хэсэг юм. Захчины хуримлах ёсны тухай Г.Мэнэс, Х.Сампилдэндэв, Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нар судалж өгүүлэл, эмхэтгэл, нэг сэдэвт бүтээл хэвлүүлж байжээ. 2002 онд “Монголын утга соёлын өвийн үндэсний төв” Ховд аймгийн Манхан сумын нутгийн иргэд, ардын авьяастнуудыг оролцуулан “Алтан тулга, мөнгөн тогто” баримтат киног хийсэн. Энэхүү баримтат киноны зохиолыг Г.Мөнхзогс бичиж, найруулагч, зураглаачаар Г.Жамсран, зөвлөхөөр Ж.Энэбиш, А.Баасанхүү нар ажиллажээ. Нийт 2 ангиас бүрдэх энэхүү киноны нэгдүгээр анги нь 1 цаг 49 минут, хоёрдугаар анги нь 1 цаг 27 минутын урттай. Захчин угсаатны хуримын зан үйлээр нэг л баримтат кино хийгдсэн нь “Алтан тулга, мөнгөн тогто” юм.

Монголын нүүдэлчдийн уламжлалт соёл нь олон зууны туршид хадгалагдаж ирсэн ч орчин цагийн нийгмийн өөрчлөлт, суурин соёл иргэншлийн нөлөөнд зарим уламжлал мартагдах, алдагдах эрсдэл тулгарч байна. Энэ утгаараа соёлын биет бус өвийг судлан баримтжуулах, хадгалан хамгаалах нь нэн чухал юм.

Баримтат кино нь нийгмийн амьдралын хөдөлшгүй баримтыг уран бүтээлч ашиглан, цаг үеийнхээ тухай, хүний амьдрал хувь заяаны тухай өөрийн хувийн үзэл бодлыг уран сайхны аргаар нээн гаргаж үзүүлдэг урлагийн нэг хэлбэр юм (Чимид 2024, 14). Соёлын биет бус өвийг баримтжуулах гол зорилго нь өнгөрсөн үеийг бодит байдлаар нь хадгалан үлдээх, ирээдүйд нээлттэй хүртээмжтэй болгох явдал юм (Отгонбаяр 2024, 69). Баримтат кино нь соёлын биет бус өвийг судлан баримтжуулах, түүхэн хөгжлийн явцад хэрхэн өөрчлөгдөж буйг олон талт өнцгөөс тайлбарлах боломж олгох судалгааны нэг эх сурвалж болох боломжтой.

Монголын нүүдэлчдийн уламжлалт соёлыг хамгаалах, шинэ нөхцөлд тохируулан залуу үед үндэсний соёлын үнэ цэнийг ойлгох, мэдрэх, түүгээр бахархах ухамсрыг төлөвшүүлэх арга замыг судлан боловсруулах нь тулгамдсан асуудлын нэг юм. Хэдийгээр хуримын зан үйлийг судалсан өгүүлэл, ном бүтээлүүд хэвлэгдэн гарч байгаа ч эдгээр нь залууст тэр бүр хүрэхгүй, залуучууд ч сонирхон судлахгүй байгаа нь анзаарагдаж байна. Ийм нөхцөлд баримтат кино нь соёлын өвийг баримтжуулах, олон нийтэд ойлгуулах, соёлын залгамж халааг дэмжих үр нөлөөтэй хэрэгсэл болж болох юм. Иймээс энэхүү өгүүлэлдээ баримтат киноны нэгдүгээр ангид дүрслэгдсэн захчины хуримын зан үйлийг уламжлалт хуримын зан үйлтэй нь харьцуулан судалж, хэрхэн хадгалагдаж, өөрчлөгдсөн байдлыг тодруулахыг зорилоо.

Судалгааны арга зүй

Захчины хуримын зан үйлийн уламжлалыг тодруулахдаа харьцуулалт, баримт бичиг, видео материалд задлан шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэсэн.

Судалгааны үр дүн

Уламжлалт хуримын зан үйлийг хуримын өмнөх, хуримын үе, хуримын дараах гэсэн хэсгүүдэд хуваан авч үздэг. Энэхүү баримтат киноны нэгдүгээр ангид *хуримын өмнөх үе, хуримын үеийн* зан үйлийг онцлон үзүүлжээ. Тухайн хэсэгт

хамаарах зан үйлүүд хэрхэн дүрслэгдсэнийг уламжлалт хуримын зан үйлийг судалсан дээрх судлаачдын судалгаатай харьцуулан шинжилсэн болно.

Хуримын өмнөх зан үйлд **бэр сонгох, ам сонсгох, зус хадгийн найр, халхаар цайлуулах** зан үйлүүд байдаг бол энэхүү кинонд эдгээр зан үйл бүгд багтжээ. Хуримын үеийн зан үйлээс **гэр бүрэх, гэр нүүлгэн барих** зан үйл гарах бөгөөд 2 дугаар ангид хуримын үеийн **бэр буулгах, бэр мөргөх, арьс татах, хөшиг тайлах** зан үйлүүдийг илэрхийлсэн байна.

Бэр сонгох: XIX зууны сүүлч, XX зууны эхэн үед захчингууд хүүгээ их төлөв 17, 18 насанд нь гэрлүүлдэг байжээ. Хүүгээ хэдийд гэрлүүлэх нь тухайн айлын хөрөнгө чинээнээс хамаарч чадал чансаатай нь хүүгээ эрийн цээнд хүрмэгц эртхэн гэрлүүлдэг байсан ба бололцоо муутай нь 25 наснаас хэтрүүлэлгүй гэрлүүлдэг байсан гэнэ (Баасандорж, Очир 2019, 91). Баримтат кинон дээр гарч буй хүүг Цогбадрах гэдэг бөгөөд морь жилтэй 25 настай. Түүний эхнэр болох Тунгалаг нь хонь жилтэй 24 настай. Бэр сонгохдоо насны зөрүүг хэрхэн харгалздаг байсан талаар Г.Мэнэс “...Эхнэр нь нөхрөөсөө 1, 3, 8 нас дүү байвал эрхэм заяаных...” (Мэнэс 1996, 354), А.Баасанхүү, Б.Батмөнх “...насны хувьд хүүгээсээ аяганы ах буюу нэг насаар ах эхнэрийг сайн гэдэг байжээ. Гэхдээ тэр болгон нэг ах тохирох эхнэр олддоггүй тул их төлөв дүү эхнэр авч өгдөг байсан...” (Баасанхүү, Батмөнх 2010, 183), Ч.Туулцэцэг “...аага (аяга)-ийн ах авгай заяаных хэмээн бэлгэшээж хүүгээ нэг насны эгч хүнтэй суулгахыг эрхэмлэх, 3, 8 насны дүү, ивээл жилтэй бол сайн гэдэг...” (Туулцэцэг 2021, 132) гэж тэмдэглэжээ. Кинонд хосууд нэг насны зөрүүтэйг

- Удам угсаа сайтай, жил нас нь ч гэсэн энэ хоёр чинь юу билээ дээ. Нэг л дааган ах дүү бил үү дээ.
- Манай айлын хөвүүн морь жилтэй, танай охин хонь жилтэй гэсэн үү. Дааган ах дүү улс юм байна аа гэх зэргээр тодруулж харуулж байна.



Зураг 1. Хүүгийн аав хөгийн аавынд очиж зөвшөөрөл авч байгаа нь¹

Баримтат кинонд хүү ээждээ “Би Палам гуайн Тунгаатай гэр бүл болох санаатай, та аавд хэлж өгөөч” гэж хэлнэ. Уламжлалт хуримын зан үйлд эцэг эхийн сонголтыг чухалчилдаг бол энэ хэсэг нь орчин үеийн гэр бүлийн харилцаанд

¹ Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г. (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино*.

хувь хүний сонголт, хайр сэтгэл нь хурим хийх үндэс болж буй шинэ хандлагыг харуулж байна. Үүний дараа хүүгийн аав хөгшин ааваасаа энэ тухай асуухаар очиж буйг хэсэг гарна (Зураг 1). Уламжлалт ураг барилдах ёсонд тодорхой хэм хэмжээг баримталж ирсэн. Юуны өмнө яс, элкийн хамаарал, садан төрлийн холбоо, хөрөнгө чинээний байдал, удам, угсаа зэргийг голлон анхаардаг. Хамгийн гол нь элкин, ургийн хүмүүс өөр зуураа гэрлэхийг хатуу хориглож байв (Туулцэцэг 2021, 131). Баримтат кинонд дүрслэгдсэн захчины хуримын зан үйлийн нэгэн чухал хэсэг нь бэр сонгох, ураг төрлийн холбоо хамаарлыг лавлах, ахмадтай зөвлөлдөх үйл явц юм. Бэр сонгож байгаа нь хэдий орчин үеийн мэт боловч нөгөө талдаа уламжлалт хуримын хүрээнд ураг төрлийн холбоо хамаарлыг харгалзан үзэж, ахмадуудаас зөвшөөрөл авч байж албан ёсны болж байгаа нь харагдана.

Хүүгийн аав:

- Манай хүү Цогбадрах Паламын Тунгалаг хоёр сэтгэл санаа нийлжээ. Одоо хүүхдээ айл болгох талаас нь хөөцөлдье гэж бодоод... Паламынхтай манайх урьд хойно элкин² ураг нь юу билээ?" хэмээн хөгшин ааваасаа асуухад
- Манайх чинь Жамудайн элкийн улсууд. Тэдний элкintэй хамаарахгүй ээ. Ямар нэгэн төрөл садны холбоо байхгүй, болно гэж бодож байна" хэмээн зөвшөөрөл олгож байна.

Энэ нь уламжлал, шинэчлэл хэрхэн зэрэгцэн оршиж байгааг харуулахаас гадна орчин үеийн хуримын хэлбэр нь уламжлалт хуримын соёлын дотоод зохицлын хүрээнд зохицуулагдаж байгааг харуулжээ. Захчины хуримын уламжлалд ураг төрлийн холбоо, хамаарлыг тодруулах, ахмадуудтай зөвшилцөх нь гэр бүл үүсгэх үйл явцын салшгүй хэсэг байсаар ирсэн. Хөгшин аав:

- Урьд нь богтлох ёс, орлуулах ёс гэх мэт янз янзын юм байсан. Одоо юмаа ил цагаан хэлэлцээд, илэн далангүй хэлэлцдэг болсон нь бас нэг ёсны зөв зүйл

гэхчлэн түүхэн цаг үеийн зан үйлийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч буйг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, уламжлалт амьдралын хэлбэрүүд цаг хугацаатай хамт уян хатан болж, шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадамжтай байдаг соёлын амьд чанарыг тусгажээ.

Бэр гуйх: Энэхүү зан үйл нь ам сонсгох, хадаг бараалхуулах, идээний дээж өгөх, хуйх хүргэх, зус өгөх, халхаар цайлуулах зэрэг ёслолоос бүрдэнэ.

Ам сонсгох: Ам сонсгоход хүүгийн эцэг эх биеэрээ оролцохгүй, харин эцгийг төлөөлөн цэцэн цэлмэг, уран үгтэй хоёр хашир хүн зуучилдаг. Энэ хоёр зуучийн нэг нь хүүгийн авга ах байх гэх бөгөөд энэхүү заншлын утга нь “хадгийн эх самбай, хадмын эх авга” гэсэн зүйр үгтэй холбогдоно (Мэнэс 1996, 354). Баримтат кинонд энэ уламжлал хадгалагдаж, хүүгийн аав хөгшин аавтай зөвлөлдөн, ам сонсгоход хэнийг явуулах тухай ярилцдаг. Эрдэнэбүрэн гэх хүнээр зууч томилж буй хэсэгт түүнийг ёс жудагтай, олон айлын найрт оролцож явсан ноён нуруутай хүн гэдгийг харуулж байна. Хүүгийн аав Эрдэнэбүрэн болон өөр нэг эрэгтэйг урьж гэртээ авчруулж буй хэсэгт:

² Төрөл садан, овог удам (Баасанжав, Амгалан 2021, 465)

- Манай Галаа чинь Паламын Тунгаатай гэр бүл болохоор, айл болохоор хэлэлцсэн юм болж байна уу?
- Тэгэж байна.
- Тэгэлгүй яах вэ, Үртэй хүнээс үр залгадаг Үндэстэй модноос мөчир уядаг жамтай. Хорвоон ажил одаа шамдана аа түргэлнэ ээ. Залуугаа айл хийгээд авна.
- Одоо ам сонсгох ажилд таныг явж өгийт³ ээ гээд хөөргөө барина.
- Аман тамхи, цагаан тамхи гуйх ажилд бид хоёрыг явж өгөөч ээ гэж дуудсан юм болжийно уу?
- Хүүхдийн найр хуримны ажлыг ер нь та хариуцаж айл болгож өгийт ээ гэж тамхиа барьж байна аа.
- Өө жаа, төрийн бүтдэг юм бүтэх байлгүй дээ. Хүүхэд нэг ам нээж айл болно оо гэснээс цааш бүтдээрээ дэмнээд айл болгоод авалгүй яхав.

Энэхүү харилцан яриа нь хүндлэлийг уламжлалт үг, зан үйлээр илэрхийлж байна. Үндэстэй модноос навч ургадаг биш үү, үртэй айлаас өрх өсдөг биш үү хэмээн энэ ажил хэргийг бүтээхийн төлөө тавтай бүтэлтэй, үг гарлыг хийнэ (Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургууль Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 14). Ам сонсгоход охины ээж хүүгийн талын зуучийг “Энэ нөгөө хэзээнээс нааш үгийн баялагтай юм болохоор энэ маань олон айлын охин залуун ажилд оролцож явна” гэдэг нь зөвхөн магтаал биш, албан ёсны үүрэг хүлээсэн хүн болохыг баталгаажуулсан үнэлгээ юм. Мөн зууч өөрийгөө “Энэ тавин хэдэн наснаас илүү хэссэн айлын тоо одоо 70 хүрч явна, одоо хурим ахалдаг нас нь өнгөрөх гэж байна, хөл гар өвдөөд...” гэх нь өөрийн арвин туршлага, оролцсон айл бүрийн тоо нь нэг төрлийн үнэлэмж болж байгааг илтгэж байна. Ийнхүү зуучийг сонгосны дараа охиныд очиж тамхиа өгч, хүү талаас хадаг ирэх гэж буйг сонсгоно (Баасандорж, Очир 2019, 91). Зууч нар очоод зорилго санаагаа илтгэсэн уран цэцэн холбоо шүлэг хэлдэг байжээ. Иймд зуучийн хүнийг сонгохдоо цэцэн цэлмэг, уран үгтэй хүн олохыг чухалчилдаг байв (Сампилдэндэв 1981, 23).



Зураг 2. Анхны ам тамхийг охины аав, ээж, хөгийн ээжид өгч байгаа нь⁴

Баримтат кинонд “танай хоёр чинь худаан ураг болдог”, “худ анд”, “хүүхдийн ажлаар явууллаа” гэхчлэн хүү охин хоёрын харилцааг хэлэлцэхээр ирснээ илэрхийлж байна. Зууч:

³ Өгнө үү та, та өгнө үү /ах, ахмад болон хүндэтгэвэл зохих хүнд хандах үг/ (Баасанжав, Амгалан 2021, 286)

⁴ Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г. (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино*.

*Жаа хавс⁵ хавсандаа түшиг
Хавсан нь сээртээ түшиг
Халиавал⁶ хар нүдэн
Хатгавал хар цусан
Ижил малтай ихэр буурьтай
Ах дүү аймаг садан билээ бид
Манай хайсан жил ус нь танайд байж ээ
Ингэхдээр
Дээгүүрээ үүлэн холбоо
Доогуураа үндсэн хэлхээ
Татаад тасаршгүй
Матаад матрашгүй
Мянган жилийн ураг элкин*

Түмэн жилийн төрөл элкин болохоор бид хүүхдээ танай охиныг түшүүлж амьдрал залгуулахаар ингэж хэлэлцэх аман тамхийг азай буурал аав, ачит буурал ээж, эмгэн буурал эмээ та бүхэнд тамхи бараалхуулахаар ирсэн билээ гээд хэрэг зориггоо хэлж байна (Зураг 2). Энэ нь хоёр талын угсаа, мал сүрэг, нутаг усны холбоог тодотгож, гэр бүл болох нөхцөлийг тайлбарлан амьдралыг нэгтгэе гэсэн санааг илэрхийлжээ. Энэ нь зөвхөн хоёр хүний харилцаа бус, хоёр гэр бүлийн, цаашлаад хоёр ураг элкийн хэлхээ холбоог тогтоох эхлэл болж байна.

Хадаг бараалхуулах: Ам сонсгосны дараа ураг холбох айлд хүү талаас 2-3 хүн хадаг, алчуур, идээ цагаа, архитай очно. Энэ үед бэр болох охины ах дүү, арал төрлийн гол хүмүүс цугласан байна. Хүү талаас очсон хүмүүс цайлсны дараа хадаг бараалхуулж ирснээ хэлж эхлээд үсээ (сүү) алтайд өргөнө, дараа нь галд дусаана, дараа нь нь өрхөөд нь өргөөд аав, ээж хоёрт нь барина (Баасандорж, Очир 2019, 92). Хүү тал ирээд цагаан идээгээ бяслаг, өөд нь хойморт тавина. Сүү, айраг, архиа охины талынханд амсуулна. Хамгийн эхлээд сүү, эсвэл айраг (авчирсан байдлаар)-аас охины аавд, ээжид, ах дүү г.м. бүх улсад амсуулдаг ёстой. Хоёр хүний амьдрал цагаан идээ шиг ариун сайхан яваарай гэсэн учиртай юм (ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургууль Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 250). Баримтат кинонд хүүгийн талаас ирсэн зочид гэрт ороод охины талынхантай мэнд мэдэж хөөрөглөнө. Цайлсны дараа хүүгийн талын зууч “*Азай буурал аав, ачит буурал ээж, ах дүү төрөл төрөгсөд та бүхэнд үр хүүхдийн хадгийг бараалхуулъя*” хэмээн хэлж охины аавтай дахин хөөрөглөнө. Үүний дараа тавагтай идээн дээр байгаа тосноос хадагт түрхээд бурхан дээр тавилаа. Дараа нь сүүгээ алтайд өргөв.

Зууч:

*Эрж байсан эрдэнэ энэ өргөөнд байна гээд
Зурхайч ламаар зуруулаад
Зуучийн хүнээр зуучлуулаад
Танай өндөр босгыг тань алхаад өргөөнд чинь ирэв ээ.
Буга намнаач нь манайд байна*

⁵ Хавс/ан/-Хавирга (Баасанжав, Амгалан 2021, 376)

⁶ Юмыг харах, үзэх (Баасанжав, Амгалан 2021, 383)

Булга зүүгээч нь танайд байжээ

Танай үр нь манай болж

Манай үр нь танай болжээ

Ингээд азай буурал аав, ачит буурал ээж үр хүүхдийн хуримын үйл ажиллагааны хадаг бараалхуульяа аа гээд хадаг мөнгөн аягатай сүү охины аавд барина. “Буга намнаач нь манайд, булга зүүгээч нь танайд” гэх зэргээр хүргэнийг булга намнадаг анчин гөрөөчний байдлаар, бэрийг булга халиу зүйдэг оёдолчны байдлаар харуулсан нь түгээмэл бөгөөд эртний хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд ялгагддаг байсан ажлын онцлогтой холбоотой байж болох юм (Сампилдэндэв 1981, 25). Дараа нь хүүгийн зууч идээний дээжийг морин сарын 13-ны туулай өдөр бараалхуулахаар тогтоод:

Азай буурал аав

Ачит буурал ээж ах дүү төрөл төрөгсөд хуран цугларсан та бүхэнд

Хоёр хүүхдийн хадгийн үйл ажиллагаа маань санасанчлан

Хоёр хөөргийн харшаангүй

Хоёр үгийн зөрүүгүй сайхан боллоо

Хойшдын ажил улам сайхан болох болтугай гээд мордохын тамхи барьяа гэж хөөрөглөөд явцгаана. Хадаг бараалхуулах ёслол нь зөвхөн гэр бүл болох хосуудын хоорондох аман хэлэлцээр биш хоёр ургийн холбоо баталгаа болж байгаа нь харагдаж байна.

Идээний дээж өгөх: Хуучин цагт хадаг өгснөөс хойш 1-2 сарын дараа идээний дээж өгнө. Энэ үед хүүгийн төрөл садан найрч 3-5 хүн идээ цагаа, архи, хадаг, алчуур зэрэг зүйлс авч ижил зүсмийн морь унаж очно. Тэд цайлсны дараа ахлаач тамхи нэрж идээний дээж бараалхуулж ирснээ хэлнэ. Улмаар идээгээр дээж тавьж, сүү, архи аmsуулна (Баасандорж, Очир 2019, 94). Баримтат кинонд хүүгийн талаас хүмүүс ирж охины аавын гэрт орно. Идээний дээж хүргэхэд 1. Хадаг, бяслаг, ааруул 2. Хадаг, модон тавагтай бяслаг, ааруул гээд нийт хоёр удаа бурханд нь идээ тавив. Идээ тавих бүртээ малгайгаа аваад бяслагийн дөрвөн буланд тос түрхэж байна (Зураг 3). Үүний дараа зууч:

- За ингээд хоёр хүүхэд маань сэдэж хорин хүн маань товлож хэлэлцсэн ёсоор бид үр хүүхдийнхээ идээний дээж бараалхуулахаар ирлээ. Азай буурал аав ачит буурал ээж ах дүү төрөл төрөгсдөдөө хүүхдийн идээний дээж бараалхуульяа аа гээд охины аавтай хөөрөглөсний дараа:

Холыг ойртуулж

Хоёрыг уулзуулж

Хорин хүн хошуучилж

Арван хүн ахалдаг хуримын даа⁷ хоёр хүүхдийн идээний дээж бараалхуульяа гэж зөвшөөрлийн тамхиа барьяа аа гэхэд:

- За аав ээж буурлууд зөвшөөрсөн болохоор одоо би ингээд зөвшөөрөлгүй яахав гээд хөөрөглөнө.

⁷ Захчин хурим найрын ахлагч, ахлаач (Баасанжав, Амгалан 2021, 113)



Зураг 3. Бяслагийн дөрвөн буланд тос түрхээд бурханд идээгээ тавьж байгаа нь⁸

Идээний дээж өгөх ёс дээр ааваас гадна охины талын найрын даагаас зөвшөөрөл эрж хөөрөглөж байна. Идээний дээж өгөх нь хадаг бараалхуулсны дараах чухал үе шат бөгөөд хуримын зан үйлтэй холбоотой өдрүүдийг хоёр тал хэлэлцэн товлдог. Баримтат кинонд хүүгийн зууч идээний ажил дээр хэлэлцдэг мундаг асуудалдаа орцгооё гээд **хуримын өдөр, зусны идээ авчрах өдөр, хуйхын идээ авчрах өдөр, ор ирмэг эсгэх өдөр, хүргэн үзэгдэх өдөр, гээг буулгах өдөр, зам цайлгах өдөр, хуримын мэдээ** зэрэг өдөр судрыг товлж байна. Эдгээр өдрүүдийг товлхдоо хэд хэдэн хүчин зүйлийг сайтар харгалзан үзэж байна. Үүнд,

1. Хүү, охины төрсөн жил, ивээл өдрүүдийг харгалзах: Хойн⁹ сарын шинийн гунанд (гурванд) гахай өдөр зусны идээ авчиръя, хуйхын идээг зуны адаг хонин сараан 15-ны дүүрэн сартай гахай өдөр гэдгээр тус тус **охины ивээл өдөр**; гэр барих, ор ирмэг эсгэх бар өдөр, хүргэн үзэгддэг ажлыг намрын дунд сарын шинийн 7-нд цагаан бар өдөр гэдгээр тус тус **хүүгийн ивээл өдрийг** харж шийдэж байна.
2. Зан үйл тус бүр хуримаас хэд хоногийн өмнө байх ёстой талаар уламжлалт хугацааг баримтлах: Хүргэн үзэгддэг ажлыг намрын дунд сарын шинийн 7-нд цагаан бар өдрөөс гадна хуримаас 10 хоногийн өмнө энэхүү өдөр таарах; гээг буулгах өдөр намрын дунд сараан 12-ны хонь өдөр гэж хэлэхэд тав хоногийн өмнө энэ болохгүй байх аа гэж охины талаас хэлээд гурав хоногийн өмнө гэдгээрээ л хийе гэж тохирч буй хэсэг гарч байна.

Эдгээр өдрүүдийг хоёр талын ах дүү, авга нагац хуран цугласан мөчид хэлэлцэж хоёр тал нэгдмэл ойлголт, харилцан зөвшилцөлд хүрснээрээ цаашдын зан үйл, ёс ёслолуудыг хийхэд зөрчил гарахгүй байх үндсийг тавьж, нэг төрлийн баталгаа болж байгаа нь харагдаж байна.

Зус өгөх: Хүүгийн талаас найрын ахлаач, хадаг бүслэгч, сөн түшигч, хундага баригч гэсэн үүрэгтэй 5 буюу эсвэл 7 хүн оролцох бөгөөд үүнд заавал 2 эмэгтэй явдаг журамтай аж (Мэнэс 1996, 356). Баримтат кинонд хүүгийн аав, найрын ахлаач, 1 эрэгтэй, 2 эмэгтэй ирж байна. Гэрийн гадаа буугаад ууттай савтай зүйлийнхээ амыг нээгээд гэрт оров. Найрын ахлаач дөрвөн буланд нь тос түрхсэн бяслагийг авдар дээр бурхны өмнө тавина. Авдар дээр идээ тавихдаа хадгийг заавал урагш нь унжуулан тавьж байна. Хонины ноосон дээр хадаг, хуруун чинээ зус¹⁰ наагаад:

⁸ Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г. (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино*.

⁹ Хонь (Баасанжав, Амгалан 2021, 396)

¹⁰ Буцалгаж авсан цавууг захчинаар “зус” гэнэ. (ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургууль Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 80)

Танай үр нь манай үр нь боллоо

Манай үр нь танай үр нь боллоо

Шар зусаар наалаа

Шалзад¹¹ хадаасаар хадлаа

Азай буурал аавдаа ингээд үр хүүхдийн зуснаа идээ бараалхуулъя аа гэж хэлэхэд охины аав:

- Жаа ёстой юм ёсоороо төртэй юм төрөөрөө боллоо. Ингээд үр хүүхдийн цаашдын ирээдүй сайхан байх болтугай гээд авч байна (Зураг 4).

“Зус” өгснөөр буцалт няцалтгүй боллоо гэж үздэг. Дараа нь тэнд цугласан ах дүүсийн гарыг цайлгана (Баасандорж, Очир 2019, 95). Эцгээс эхлэн хадгийг охины талын хүн бүрт аягатай сүү, хундагатай архины хамт барин гар цайлгаад найраа эхэлдэг (Мэнэс 1996, 357). Гар цайлгаж байгаа хэсэг кинонд гарсангүй. Хүүгийн тал ёс төрөө гүйцэтгэсний дараа, охины тал зус хүргэж ирсэн хүмүүсийг дайлна. Ингэхдээ тулган дээр тогоо тавьж түүнийгээ дүүргэнэ. Улмаар хоёр халбага дүрж хоёр талд аягалан бага зэргийн найр үүсгэнэ (Баасандорж, Очир 2019, 95). Энэ зан үйл баримтат кинонд гарч байна. Охины аав:

- Жаа самган галаа хийтэн. Хүүд хайсаа¹² тавь. /Охины ээж галаа түлээд тогоогоо тулган дээр тавив./

Хүүгийн найрын ахлаач:

- Жаа сархдаа хайсанд хийтэн гэхэд дашмагтай архиа тогоонд хийлээ. Бүлээсгээд самарч байна. Хүмүүст аягалаад өгөв.

Ирсэн хүмүүс өдөртөө мордох бөгөөд эцэст нь охины талын ахлаач гэрийн зүүн хананаас бууны сүмбэ¹³ аваад:

Унаж ирсэн унааны тань ул нь чиллээ

Хөлөглөж ирсэн унааны тань хөлс нь хатлаа

Ирсэн гийчин буцаж

Орсон бороо арилдийм гээд хүүгийн талын найрын ахлаач, хүүгийн аав, эрэгтэйн нуруун дундуур тэр сүмбээрээ цохив. “Зус өгөх” нь хуримын зан үйлд онцгой байр суурь эзэлдэг батламжийн хэлбэр бөгөөд хоёр талын гэр бүлийн холбоог албан ёсоор тогтоож, буцалтгүй болсныг илтгэнэ.



Зураг 4. Зус идээгээ бараалхуулж байгаа нь¹⁴

¹¹ Шалзан хадаас, нимгэн тавтай жижиг төмөр хадаас (Баасанжав, Амгалан 2021, 444)

¹² Тогоо (Баасанжав, Амгалан 2021, 381)

¹³ Бууны дотрыг цэвэрлэх ба сумны хонгиог түлхэхэд хэрэглэх хэрэгсэл (Цэвэл 1966, 496)

¹⁴ Мөнхзөгс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино*.

Хуйх хүргэх: Захчинд “хуйх хүргэнэ”, “хуйх өгнө”, “хуйх барина” гэж янз янз хэлэх боловч зан үйлийн агуулга хэлбэр нь хоорондоо төстэй юм (Мэнэс 1996, 357). Судлаачдын тэмдэглэснээр идээний дээж өгсний дараа энэхүү зан үйлийг үйлддэг гэсэн бол баримтат кинонд зүс өгсний дараа үйлдэж байна. Энэхүү зан үйл нь нутаг нутагт дэс дарааллын хувьд өөр байсан бололтой. Хүүгийн талын найрын ахлаач:

- Хуйхын идээ бараалхуулахаар ирсэн билээ бид.

Охины аав:

- Жаа, жам ёсны ажил жам ёсоороо тэгэлгүй яахав ээ.

Модон тавагт цай дусаагаад дээр нь бяслагийн дөрвөн буланд тос түрхээд хоймрын авдар дээр тавилаа. Хадгийг мөн л урагш нь унжуулав. Малгайгаа өмсөөд хадаг барин:

Охин маань манцуйтай байхдаа танайх байлаа

Магнаг өмсөхдөө манайх боллоо

Хорин салаа үс нь хоёр салаа боллоо

Хуйхтай болохдоо манайх боллоо

Хувиршгүй хуйхаан өгч

Хугаршгүй хадгаа баръя аа буурал аавд гээд охины аавд хадгаа өгөв. Охины аав, хөгшин ээж, хойморт сууж байгаа эрэгтэйд хадаг өгөв. Энэ нь хэлсэн үгнээсээ буцаж няцахгүйн тэмдэг болдог бөгөөд хэрэв үгнээсээ няцвал хуйхаа хуулуулахад бэлэн гэж битүү утгаар андгайлж буй хэрэг юм. Захчин ардын дуунд

Хуйхтай толгой хуйханд баригддаг

Хувхай толгой хананд захирагддаг гэдэг үг байдаг. Энэ хуйх барих нь хурим хийх гэж байгаа айлд хамгийн найдвартай баталгаа юм (ШУА-ийн Түүхийн хүрээлэн, МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль 2009, 138). Охины аав ээжид нь хандан:

- Жаа галаа гэж хэлэхэд

Охины ээж галаа асаахад хүүгийн талын найрын ахлаач тулганы доод талд хормойгоо тосон суугаад тулганд гурав мөргөв (Зураг 5). Ингэж мөргөх нь баталгаагаа буцашгүй найдвартай болгож байгааг илтгэж байна. Хүүгийн талын найрын ахлаач:

Хуйхын идээ бараалхуулах

Ирсэн гийчид буцдаг

Орсон бороо гийдэг жам ёсоор бид одоо мордохын тамхиа барья аа гээд хөөрөглөв.



Зураг 5. Хүүгийн талын найрын ахлаач тулганд мөргөж байгаа нь¹⁵

¹⁵ Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г. (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино*.

Хүргэн үзэгдэх: Баримтат кинонд хүү, нэг хүнтэй охины аавын гадаа ирээд гэрт орохоос өмнө дээл хувцсаа янзаллаа. Хүүг ороход охины ээж цагаан ширдэг дэвсэж өгөв. Гэрт байгаа хүмүүстэй хөөрөглөв. Үүний дараа охины аав, ээж, хөгшин ээж нь хүүд ерөөлийн үг, сургамж хайрлаж байна. Захчин хуримын талаар судалсан судлаачдын бүтээлд тэмдэглэгдээгүй нэгэн зан үйл гарч байгаа нь хүүгээр шор зоруулж байна. Охины аав:

- Миний хүү энэ гэрт одоо уламжлалт заншлаараа аавдаа энэ нэг хотаан амнаа шор¹⁶ зороод өгчих.

Хүү хутгаар модоо зороод хадам аавдаа өгөхөд *ёстой сайхан шор болж, та нар сонирхцгоотон* гээд гэрт байгаа хүмүүст үзүүлээд *миний хүү энийгээ аваад хадгалж яв аа* гээд хүүд өгч байна (Зураг 6). Энэхүү зан үйлийг гүйцэтгэхэд охины аав “*Хүнтэй дээр доор гэж ялгалгүй даруу сайхан харьцаж, эелдэг зөөлөн харьцаатай байх хэрэгтэй миний хүү*” хэмээн захиснаар хүний харилцаанд даруу төлөв, эелдэг занг эрхэмлэхийг, охины ээж “*Манай энэ хүргэн болдог хөвүүн инээсэн ийм их баясгалантай нүүртэй хөвүүн ... Сайхан илэн далангүй ярьсан найз нөхөд олонтой, цаадах манай охин чинь дураараа их эрх, энийгээ сайн түшсэн хоёр биедээ их халамжтай ийм л одоо айл болцгоотон*” бие биедээ түшиг тулгуур болохыг, хөгшин ээж “*ахаа алд хүндэлж, дүүгээ дэлэм хүндэлж яваарай*” хэмээн хэлж байгаа нь гэр бүл болж буй залууст сургамжийн үгээр дамжуулан ахуй амьдралын хэм хэмжээ, хамтын амьдралын үнэт зүйлийг захиж байна.



Зураг 6. Хүргэн хотаан амнаа шор зорж байгаа нь¹⁷

Гээг буулгах: Захчин хоёр хошуунд “үс буулгаж шанхалах”, “халхаарлах”, “гэжиг буулгах” гэж нэрлэдэг ба үүнээс хойш хүүхнийг хадамд очтол нь “буулгамал”, “халхаар”, “буулгамал үст” гэж дууддаг аж. Бас сэвгэрийн “зүс хувиргана” гэж бүсийг нь тайлж, цагаан захтай улаан цув өмсгөхөөс гадна “наснаас нь гаргана” гэж сэвгэрийн цацагтай мөнгөн ээмэг чихэнд нь зүүгээд, магнайг нь улаан даавуугаар ороож боогоод, халиутай малгай өмсгөнө (Мэнэс 1996, 358). Ц.Баасандорж, А.Очир нар гээг буулгахыг хуйх хүргэхэд хийдэг, Г.Мэнэс хурим болохоос 1-2 хоногийн өмнө гэж тэмдэглэжээ. Баримтат кинонд дээр 3 хоногийн өмнө энэ зан үйлийг хийж байна. Хүүгийн талын найрын ахлаач, нэг эмэгтэйн хамт иржээ. Хүүгийн талаас ирсэн эмэгтэй охины олон салаа сүлжсэн үсийг нь задлаад, үсийг нь нэг сүлжиж, ээмэг зүүлгэж, малгай өмсүүлж байна. Цагаан захтай улаан цув өмсүүлэв (Зураг 7). Охины олон салаа гэзгийг задалж, цув өмсүүлж байгаа нь

¹⁶ Ходоодны амыг сүвлэх нэг талын үзүүр хурц, эсрэг тал нь бүдүүвтэр мод (Баасанжав, Амгалан 2021, 403)

¹⁷ Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г. (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн тотго баримтат кино*.

айлын бэр болж байгаа дохио, бэлгэдэлт зан үйл юм. Францын угсаатан судлаач Ван Геннепийн *даваа давах ёслол* (rites of passage)-ыг салалт (separation), шилжилт (transition), нэгдэх (incorporation)” гэсэн гурван үе шатанд хуваан тодорхойлжээ (Genner 1960). Захчины гээг буулгах нь “салалт” (separation)-тай “хувь хүн эсвэл бүлгийг нийгмийн бүтэц дэх өмнөх байр сууриасаа бэлгэдлийн шинжтэй зан үйлээр тусгаарлаж буйг илэрхийлдэг” тохирч буйг харуулна.



Зураг 7. Гээг буулгах¹⁸

Халхаар цайлуулах: Хуримын өмнө гүйцэтгэх нэгэн зан үйл бол ах дүү, арал төрлөөрөө¹⁹ айлчлах бөгөөд чингэхдээ дагуул нэг эмэгтэй, үеийн сэвгэрүүдийн хамт явдаг байсан байна. Гээг буулгасан охиныг “халхаар” гэж дууддаг байсантай холбоотой “халхаар цайлуулах” гэдэг нэр гарсан биз ээ. Тэрхүү “халхаар”-т улаан цуванд цагаан зах хадаж өмсүүлдэг байжээ (Баасандорж, Очир 2019, 95). Баримтат кинонд охиныг 2 талаас нь 2 эмэгтэй сугадан явна. Нийт 3 айлд ороод цай ууцгаагаад, өвчүү идэж байна.

Гэр бүрэх: Хүүгийн тал гэр бүрнэ. Гэр бүрэхийн тулд хүүгийн эцэг гэрийн мод төхөөрч ах дүү, арал төрөлдөө гэр бүрэх хугацаагаа хэлж урина. Ах дүүс нь өөр өөрсдийн бололцооны сэлбэгээ²⁰ авч ирж оролцоно. Гэрийн тооныг настай, тохирох ивээл жилтэй хүн босгох ба гэр битүүлсний дараа мөн жил нас таарах хүн гал асаана. Гэрийн бүрэлгэнд²¹ сэвгэр талыг урина. Энэ үед сэвгэрийн ээж 1-2 хүний хамт идээ цагаа, өрхний оосор авч ирж, оосроо хадаж өгнө. Гэр бүрсний дараа бага зэргийн найр хийж, гэрээ ерөөж, мялаана (Баасанхүү, Батмөнх 2010, 185). Баримтат кинонд хүүгийн талынхан гэр барьж байхад охины ээж, 1 эмэгтэйн хамт ирээд өрх оёлцоод оосрыг нь хадаж өгнө. Өрхөө гэр дээр тавихаас өмнө өрх дээр хүүхдүүд суулгаад гурав дахин дээш өргөөд буулгаж байна. Захчинд өрх дээр хүүхдүүд суулгасан бол Баядад хүүгийн эцгийг суулган хийдэг. Үүнийгээ өрх хэлбэх ёс гэдэг. Хүүгийн аав хадгийг тоононы чагтаганаас уяад ерөөл хэлсэн боловч үг нь сайн ойлгогдсонгүй. Хүүгийн талын найрын ахлаач чагтаганаас барьж байгаад:

¹⁸ Мөнхзогс, Г. (зох.), Жамсран, Г (найр.). 2002. *Алтан тулга, мөнгөн томго баримтат кино*.

¹⁹ Эцгийн талын ясан төрөл, эхийн талын цусан төрөл (Баасанжав, Амгалан 2021, 34)

²⁰ Товлосон өдөр гэрээ бүрэх ба ах дүүс нь идээ цагаа, хэдэн зах утас, оосор бүчнээс авхуулаад өөр өөрийн боломжийн сэлбэгээ авч ирж оролцоно. Ийнхүү сэлбэг авч ирэхийгээ “гэрийн нэмэр” гэдэг (Баатархүү, Одсүрэн 2019, 82).

²¹ Шинэ гэрийн бүрлэг /бүрлэгийн найр/ (Баасанжав, Амгалан 2021, 79)

*Оройнаа наран мэт мандаж
Өөмийн цэцэг мэт дэлгэрч
Артай торгоор авдраа дүүргээд
Аав ээжийн буянаа барин өтөл өө миний хүү
Намсрай бурхан шиг баян бол
Найдан жүдэг бурхан шиг өнөр бол
Өргөн газар зэлээ тат
Өндөр газар өргөөгөө барь
Урт удаан насалж*

Сайн сайхан жаргахыг хүүхдүүддээ ерөөе өө ах нь гээд ерөөлөө хэллээ. Баримтат кинонд шинэ гэрийн гал асаах ёслол гарсангүй. Шинэ гэрийн гал асаах ёслол нь монголчуудын хуримын зан үйлийн нэгэн чухал хэсэг бөгөөд гэр бүл шинээр бүрэлдэх үйл явцыг бэлгэдэн илэрхийлж, эцгийн гал голомтоос өрх тусгаарлан эдийн засаг, нийгэм соёлын хувьд бие даасан нэгж болж буйг харуулдаг.

Гэр нүүлгэн барих ёс: Хүүхнийг мордуулж авах, гэрээрээ очиж авах гэсэн хоёр хэлбэр байна. Бэрийг “мордуулж авах” нь маш эртний хэлбэр. “Гэрээр авах” нь хожим буй болсон зан үйлийн учир холбогдолтой хэлбэр юм (Эрдэнэцэцэг 2010, 48). Ц.Баасандорж, А.Очир, А.Баасанхүү, Б.Батмөнх нарын судалгаанд гэрээрээ очиж авах тухай тэмдэглээгүй. Харин энэхүү зан үйлийг “зам цайлгах” гэдэг тухай Г.Мэнэс “...бэр буулгахаас нэг хоногийн өмнө хүүгийн тал зам цайлгана гэж их хуримын мэдээг хүргэж, өртөө буюу түүнээс холгүй газар хүүхний эцгийн дээхэн зүүн талд нь буудаг. Үүний учир хүүхнийг өөдөө ус сөрж өгдөг заншил буюу усны урсгал дагуулж авдаггүй цээртэй холбоотой...” (Мэнэс 1996, 358) гэжээ. Баримтат кинонд гэрээрээ очиж авах буюу зам цайлгах зан үйл гарч байна. Хүүгийн тал барьсан шинэ гэрээ буулгаад 5 тэмээнд ачаад нүүж байхад нь тавагтай идээ, домботой цай, ширдэг барьсан настай эмэгтэйчүүд хүүхдүүдтэй ирж байна. Монголчууд нүүдэллэх хэв заншилд “нүүдлийн цай” уух, хүргэх зан үйл бүхий уламжлал байдаг. Нүүдэл ирж явахад таних, танихгүй, тэдний эдний нүүдэл ирж явна гэхгүйгээр ойр орчны айл заавал шинэ цай чанаж, идээ цагаа таваглан тосож очин “нүүдлийн цай”-гаар дайлдаг (Баатархүү, Одсүрэн 2019, 202). Хүргэн хүү хуримын урьд өдөр шинэ гэрээ ачаалан ирж хадам эцгийн зэргэлдээ буудаг бөгөөд ийнхүү ачаа хөсөг ирэх үед гэр барих буурин дээр худгуйн талаас багана барьсан хүн олбог дэвсээд сууж байдаг байжээ (Сампилдэндэв 1981, 42). Баримтат кинонд хүүгийн талынхныг ирэхэд нэг хүн ацтай шон бариад тосох бөгөөд ачаа ирж зогсоход:

*Атан тэмээний таваг гялалзуулж
Агт морины туурайг яралзуулж
Алсын дөрөлжийг давсан
Аль гээчийг зорьж явна вэ
Анчин гэхээр уулаар явдаггүй
Аянчин гэхээр замаар явдаггүй*

Бууран тэмээн дээр булга хэрмийн арьсыг багтаан ачсан

Атан тэмээн дээр алт мөнгө авдарлаж ачсан хүүхээ хаашаа явж байна даа гэж асуухад хүүгийн аав:

Баян хүний байрыг шинжих

Баатар хүний суурийг олох гэж явна аа гэж хариулж байна. За тэгвэл *тэр гүүр чинь энд байна аа хүүхээ* гээд ацтай шонгоороо дөрвөн чулууг заав. Заасан газарт нь чулуугаа давхарлаж тавиад гэрээ барьж байна.

Ор ирмэг эсгэх: Хүү талаас хуримын бэлтгэлийн хүрээнд хийх дараагийн нэг ажил бол сэвгэр талд очиж “ор ирмэг” эсгэх явдал юм. Энэ үед залуугийн ээж сэвгэрийнд нэг эсгий авч очно. Улмаар хоёр ээж жил нас таарсан хүний хамтаар ор ирмэг эсгэж охины талд хураана. “Ор ирмэг” гэдэг нь нүүр талд нь эмжээртэй, хоёр давхар эсгий бөгөөд түүнийг хуримаас гурав хоногийн өмнө эсгэдэг ёстой байжээ (Баасандорж, Очир 2019, 96). Баримтат кинонд шинэ барьсан гэрийн гадаа хүүгийн ээж, охины ээж, 2 эмэгтэй нийт 4 хүн байна. Охины ээж:

- Эхлээд орныхоо уртын хэмжээг авчихъя, энийг ингээд нугалаад тайрахаар яг таарах юм байна. Цэцэгчулуун одоо ивээл жилтэйгээрээ охиноо ирмэг эсгэнээ гэв.

Энэхүү кинонд гэрээрээ очиж авах зан үйл гарч байгаа учир зан үйлийн байршил өөрчлөгдөж байгаа хэдий ч жил нас таарсан хүнээр ор ирмэгээ эсгүүлж байна. Охиныг мордуулахаас 3, эсвэл 7 хоногийн өмнө ор дээр эсгэнэ. Охин халхаар хийж, охин шанхална²² гэж ярина. Охин нь 2 тал руугаа сэвгэр үстэй, бусад үсээ 18 хэсэг хувааж гөрөөд²³ гол гэзгэнд нь тана, боодог зүүчихдэг. Энэ үсийг цуцаад хоор (гэдрэг нь) ганц гөрөхийг шанхална гэж ярина. Шанхлаад л ор дэрээ эсгэнэ (халхаар хийх, ор дор эсгэх нь цаг хугацааны хувьд нэг бололтой) (ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Кембрижийн их сургууль Монгол ба дотоод ази судлалын төв 2011, 236).

Хэлэлцүүлэг

Баримтат киноны гол шинж чанар нь баримт, баримтжуулалт бөгөөд танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх, нийгэм, угсаатан, үндэстний ой санамжийг хадгалах, дамжуулан өвлүүлэх ач холбогдолтой, түүхэн судалгааны чухал эх сурвалж болдог. Тиймээс цаг хугацаа өнгөрөх тутам улам үнэ цэн нь нэмэгддэг нэгэн зүйлийн соёлын ой санамжийн архив гэж үзэж болно (Отгонбаяр 2024, 3). Энэ утгаараа “Алтан тулга, мөнгөн тотго” баримтат кино нь зөвхөн соёлын өвийг дүрсжүүлэн хадгалсан бүтээл биш, харин угсаатан судлал, соёлын антропологийн судалгаанд хэрэглэгдэхүйц эх сурвалж болох ач холбогдолтой.

Баримтат кинонд гарч буй ам сонсгоход зуучийн хэлж буй шүлэг өмнөх судалгааны эх сурвалжуудад бичигдэж байгаагүй нь тухайн хугацаанд энэ нутагт аман зохиол хэрхэн хувьсан байгааг баримтат киногоор баримтжуулснаараа шинэлэг юм. Хуримын аман зохиол нь дотоод бүрэлдэхүүний хувьд нэн баялаг байдаг нь ард түмний амьдрал түүх сэтгэл санааны олон талыг тусган янз бүрийн зориулалттайгаар үүсэж түүхэн урт замыг туулан хөгжсөнтэй холбоотой (Сампилдэндэв 1981, 6). Мөн баримтат кинонд хуримын зан үйлийн аман зохиолоос түгээмэл хэрэглэгдэж байгаа нь найр тараах ерөөл байна.

²² Бэр болох бүсгүйг эзэгтэйд хувиргах зан үйл, үс буулгах шанхлах (Баасанжав, Амгалан 2021, 445)

²³ Сүлжих (Баасанжав, Амгалан 2021, 99)

“Ирсэн гийчид буцдаг

Орсон бороо гийдэг” ерөөлийг идээний дээж өгөх, зус өгөх, хуйх хургэх, гээг буулгах зан үйлүүдэд хэлж байна. Хурим найрын ерөөлийн сургаалт уянгын шинжтэй өвөрмөц нэгэн хэлбэр нь найр тараах ерөөл юм. Энэ нь хөөгүүлийн үг, молорын үг, найр тараах ерөөл зэргээр нутаг нутагт өөр нэртэй боловч үндсэн агуулгын хувьд ойролцоо, хуримын найр тарах цаг болсныг зочин гийчдэд дохиолон мэдэгдэх үүрэгтэй (Сампилдэндэв 1981, 91). “Унаж ирсэн унааны тань ул нь чиллээ, хөлөглөж ирсэн унааны тань хөлс нь хатлаа”, “Ирсэн гийчин буцаж, орсон бороо арилдйи”, “Хоёр хүүхдийн хадгийн үйл ажиллагаа маань санасанчлан хоёр хөөргийн харшаангүй, хоёр үгийн зөрүүгүй сайхан боллоо” гэж хэлж байгаа нь аливаа юм бүхэн эхлэл төгсгөлтэй харилцан уялдаатай хэмжээ хязгаартай бас эерэг ба сөрөг талтай гэсэн гүн ухааны сэтгэлгээний нэгэн өвөрмөц элемент нь найр тараах ерөөлөөр илэрч байна. Энэхүү баримтат кинонд найр тараах ерөөлийг хуримын зан үйлийн олон үе шатанд давтамжтай хэрэглэж байгаа нь захчины хуримын аман зохиол хэрхэн уламжлагдаж байгааг харуулжээ.

Дүгнэлт

Энэхүү киноны талаар Б.Батмөнх бүтээлдээ ...Багш минь Баруун монголын захчины хуримын зан үйлийг олон жил судалсны эцэст “Алтан тулга, мөнгөн тотго” хэмээх баримтат кино хийж, уг кино нь Солонгос улсад болсон “Монгол туургатны их наадам”-д амжилттай оролцож байлаа. Киноны зураг авалтыг Манхан сумын Зэрэг гол багийн нутагт авсан бөгөөд эл кино нь захчины хуримын зан үйлээр хийгдсэн чухал баримт хэрэглэгдэхүүн болсоор байна (Батмөнх 2024, 92) хэмээжээ. Энэхүү баримтат киноны нэгдүгээр анги нь хуримын өмнөх зан үйлийг баримтжуулсан соёлын биет бус өвийг баримтжуулан хадгалах, дамжуулахад оновчтой арга хэрэгслийн нэг болох нь энэхүү судалгаанаас харагдаж байна. Нийт хоёр ангиас бүтэх баримтат киноны нэгдүгээр ангид дүрслэгдсэн хуримын зан үйлүүд нь зөвхөн баримтжуулах бус хүмүүсийн ярианы аялга, биеийн хэлэмж зэрэг судалгааны бичвэрт бүрэн илэрхийлэх боломжгүй мэдээллийг дүржүүлснээрээ угсаатан судлалын хэд хэдэн чиглэлд хэрэг болохуйц баялаг мэдээлэл, аман эх сурвалжийг агуулжээ.

Уламжлалт хуримын зан үйл нь хуримын өмнөх, хуримын үеийн, хуримын дараах гэсэн үндсэн хэсгүүдтэй. Хэсэг тус бүр өөр өөрийн өвөрмөц шинжийг агуулсан ёс, ёслолуудаас бүрддэг. Уламжлалт хуримын зан үйлд бэрээ сонгоод хүүгийн тал охины талд зуучийг явуулж бэрээ гуйгаад зөвшөөрвөл худ ураг боллоо хэмээж сүй бэлгээ өгөн баталгаажуулаад хуримын бэлтгэл ажил эхэлдэг байжээ. Гэтэл энэ зан үйл хөгжлийн шатанд хумигдсаар өнөө үед хүүгийн эцэг, эх билэгт сайн өдрийг сонгон бэрээ гуйгаад улмаар хоёр талынхан хэлэлцэн тохиролцож хуримлах өдрөө товлох болжээ. Энэ мэтээр орчин үед уламжлалт хуримын зан үйлийн зарим хэсэг нь хувиран өөрчлөгдөж, зарим нь хадгалагдан үлдсэн бол зарим нь мартагдан гээгджээ. Суурин соёл иргэншил давамгайлах болсон өнөөгийн нөхцөлд уламжлалт хуримын зан үйлийг дэлгэцийн бүтээлээр баримтжуулах нь соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах чухал асуудлын нэг болж байна.

Иймд баримтат киногоор уламжлалт хуримын зан үйлийг баримтжуулж, залуу хойч үед танин мэдүүлэх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих нь үндэсний соёл, сэтгэлгээний хэв маягийг хадгалах, хөгжүүлэх нь үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулна. Энэхүү өгүүлэл нь “Алтан тулга, мөнгөн тогто” киноны зөвхөн 1-р ангид тусгагдсан хуримын өмнөх зан үйлийг бусад судлаачдын тэмдэглэлтэй харьцуулан шинжилсэн эхний судалгааны ажил юм. Иймд цаашид 2-р ангид гарч буй хуримын зан үйлүүдийг мөн адил баримтат эх сурвалж болон энэ талаарх судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан судлах нь зүйтэй гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Баасандорж, Ц., Очир, А. 2019. *Ойрад Монголчуудын хуримын ёс*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.

Баасанжав, Н., Амгалан, Б. 2021. *Захчин аман аялгууны толь*. Улаанбаатар: Голден Легион ХХК.

Баасанхүү, А., Батмөнх, Б. 2010. *Монголын ойрадуудын соёл*. Улаанбаатар: Ган принт.

Баатархүү, Б., Одсүрэн, Д. 2019. *Монгол гэр өв соёл: тайлбар толь*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Батмөнх, Б. 2024. *Цаст Алтайн туульс*. Улаанбаатар: Ган принт.

Дашдондог, Ч. 1978. *Монгол киноны түүхэн тэмдэглэл*. Улаанбаатар: УХГ.

Мэнэс, Г. 1996. “Захчин: XIX-XX зууны зааг үе дэх Захчины угсаа гарал, засаг захиргаа, овгийн бүрэлдэхүүн.” *Монгол улсын угсаатны зүй II боть*. Ред. Бадамхатан С. Улаанбаатар: Сүхбаатар.

Отгонбаяр, Чулуунмөнх. 2024. “Баримтат кино соёлын өвийг хадгалж, хамгаалах хэрэгсэл болох нь (Телекино үйлдвэрийн баримтат киноны сан хөмрөгийн жишээн дээр).” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Сампилдэндэв, Хорлоо., 1981. *Монгол хуримын яруу найргийн төрөл зүйл*. Улаанбаатар: УХГ.

Туулцэцэг, Чигсэм. 2021. “Захчины түүх, угсаа, соёлын судалгаа (XVIII-XX зууны эхэн үе).” Ph.D дисс., Монгол Улсын их сургууль.

Цэвэл, Ядамжав. 1966. т.ү. “Сүмбэ.” *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.

Чимид, Түдэв. 2024. *Баримтат кино бүтээхүй*. Улаанбаатар: Линограф.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Кембриджийн их сургууль Монгол ба дотоод ази судлалын төв. 2011. *Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн (1977-1978)*. Боть IV. Эрх. Чулуун С., Улаанбаатар: Соёмбо принтинг.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн, МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль.
2009. *Монгол ёс заншил, зан үйлийн товчоон*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Эрдэнэцэцэг, Шинэн. 2010. “Баяд хуримын зан үйлийн бэлгэдэл.” Ph.D дисс.,
Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Гадаад хэлээр:

Van Gennep, Arnold. 1960. *The Rites of Passage*. Translated by Monika B. Vizedom and
Gabrielle L. Caffee. Chicago: University of Chicago Press.